

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/001/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас: 70342495 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 213

танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгаар үйл ажиллагааны санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан шууд захирагчийн цаглаварт хугацаанд хамрагдсан.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд аймгийн нийгмийн даатгалын газар нь төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж 25.7, тавилга эд хогшил 6.8 нийт 32.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан бэлтгэсэн байна.

632502388

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын газар нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилгын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг НДЕГ-аас 90.0 хувиар үнэлсэн байна.

Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	30,175,110.98	31,733,659.49
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,092,561,399.56	1,057,969,290.76
Нийт хөрөнгийн дүн	1,122,736,510.54	1,089,702,950.25
Нийт өр төлбөрийн дүн	577,800.00	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,122,158,710.54	1,089,702,950.25
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,122,736,510.54	1,089,702,950.25
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,106,119,204.55	1,703,928,643.14
Үйл ажиллагааны зардлын дүн	1,150,224,740.68	1,736,384,403.43
Үйл ажиллагааны үр дүн	(44,105,536.13)	(32,455,760.29)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	(44,105,536.13)	(32,455,760.29)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		1,122,158,710.54
Тайлант оны үр дүн		(32,455,760.29)
Эцсийн үлдэгдэл		1,089,702,950.25
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,158,765,168.18	1,698,723,103.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,155,643,293.18	1,666,196,403.00
Үйл ажиллагааны ЦМГ	3,121,875.00	32,526,700.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(32,526,700.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,121,875.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	149,671.98	149,671.98
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,671.98	149,671.98
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,613,767,300.00
Урсгал зардал		1,613,767,300.00
Хөрөнгийн зардал	0	0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,613,767,300.00
Улсын төсвөөс санхүүжих	1,613,767,300.00	1,613,767,300.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0	0

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлэх, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Зорилго: Тус байгууллага нь 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болох” хэтийн зорилготой, “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Зорилт:

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах
- ✓ Нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах

- ✓ Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах,
- ✓ Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг хүрээнд

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,033.56 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,718,673.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгож, гүйцэтгэлээр 1,572,829.08 мянган төгрөг буюу төсвийн 92.3 хувь зарцуулж 131,100.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулиар цахим хуудсанд мэдээлэхээр заасан мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 36 гүйлгээний 1,470,659.1 зарлагын 39 гүйлгээний 592,930.7 мянган мэдээллийг байршуулсан

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,092.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 9,909.4 мянган төгрөгийн 2 Төлбөрийн акт, 10,182.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

8.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд улсын байцаагчийн эрхийн шалгалтад оролцсон таван албан хаагчдад албан томилолт болон зам зардлыг байгууллагаас давхардуулан 328.0 мянган төгрөгийг олгосон.

2. Тайлант онд 14 албан хаагчид Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг нийт 95,814,118.0 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосноос ХХОАТ болох 9,581,411.0 төгрөгийг суутган тооцоогүй.

8.2 Албан шаардлага Байхгүй

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Үндсэн хөрөнгийн дансанд 10,182.9 төгрөгийн 41 нэр төрлийн хөрөнгө үлдэх өртөггүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 41 нэр төрлийн 10,182.9 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дүгээр сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зам зардлыг давхардуулан цалингийн зардлаас олгосон	1	328.0	1	328.0	0	0	0	0	0	0	0	0
Тайлант онд 14 албан хаагчид Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг нийт 95,814,118.0	1	9,581.4	1	9,581.4	0	0	0	0	0	0	0	0

төгрөгийн мөнгөн урамшуулал олгосноос ХХОАТ болох 9,581,411.0 төгрөгийг суутган тооцоогүй.												
Үндсэн хөрөнгийн дансанд 10,182,966.51 төгрөгийн анхны өртөг бүхий 41 нэр төрлийн хөрөнгө үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна.	1	10,182.9	0	0	0	0	1	10,182.9	0	0	0	0
Дүн	3	20,092.4	2	9,909.4	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-